

Хятадын их, дээд сургуулиудын ерөнхий эрдмийн хичээлийн ахиц дэвшил, бэрхшээлүүд

*Зууннаст,
Өвөр Монголын Багийн Их Сургуулийн
Үргэлжлэх боловсролын сургууль.*

Хураангуй

Ерөнхий эрдмийн хичээлийн зорилго, агуулга, хэрэгжилт, үнэлгээнд түшиглэн Хятадын их, дээд сургуулиудын сургалтын чанарыг бүх талаар дээшлүүлэх туршилт судалгааг арав гаруй жилийн турш явуулсны дүнд ерөнхий эрдмийн боловсролын бодит байдалд оршиж буй асуудал бэрхшээлийг тодорхойлсон ба ерөнхий эрдмийн сургалтын гол чиг үүрэг нь сургалтын агуулгыг гүнзгийрүүлж, үнэлгээний системийг сайжруулах явдал болохыг онцолж буй юм. БНХАУ-ын их, дээд сургуулиудад ерөнхий эрдмийн хичээлийн 80-аас дээш хувийг заавал судлах хичээл эзэлж, бүгдийг нь нэг, хоёрдугаарт курсэд судлахаар төлөвлөсөн байдаг тул ихэнх нь поток лекцийн хэлбэрээр маш бага хувь нь семинар, танхимын ярилцлагын хэлбэрээр ордог асуудлыг хөндөж, энэ нь сургалтад ямар эерэг болон сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа талаар судлав. Гадны орнуудын туршлагаас харахад, ерөнхий эрдмийн боловсролын сургалт хичээлийг төлөвлөн явуулахдаа тухайн сургуулийн онцлог, давуу тал, нөөц бололцоо, ирээдүйн хөгжлийн чиг хандалагад үндэслэн олон төрлийн арга замыг хэрэгжүүлсэн байдаг асуудлыг давхар хөндөн судалсан болно.

Түлхүүр үг

Ерөнхий эрдмийн боловсрол, зорилго, агуулга, хэрэгжилт, үнэлгээ

Удиртгал

БНХАУ-ын боловсролын салбарт “Их, дээд сургуулиудын ерөнхий эрдмийн боловсрол” хэмээх үг хэллэгийг XX зууны 40-өөд оны үед англи хэлний “general education” гэдэг үгийг орчуулан хэрэглэх болж, энэ үеэс хүмүүсийн анхаарах сэдэв болжээ. 1949 оноос хойш их, дээд сургуулийн сургалтын системд мэргэжлийн боловсролыг хэт анхаарснаар оюутан суралцагсдын ерөнхий суурь боловсролын хөгжлийг оmtгойлж ирсэн байна. 1955 онд Боловсролын яамны дээд боловсролын хэлтэс Хятадын Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль дээр “Дээд боловсрол дахь соёлын чанарын агуулгыг нэмэгдүүлэх туршилт судалгаа” сэдэвт хурал, семинарыг зохион явуулж, ерөнхий эрдмийн боловсролын агуулгын чухлыг хэлэлцэж, энэ ажлыг ойрын жилүүдэд туршин хэрэгжүүлэх боломж нөхцлийг хөгжүүлэх талаар санал солилцсон юм. Мөн оныхоо 10 сараас эхлэн зарим сургуульд “Соёлын боловсрол”-ын туршилтын ажлыг явуулж эхэлсэн бөгөөд 1998 оноос бүхий л шатанд нэвтрүүлснээр соёлын боловсролын шинэчлэл нь дээд боловсролын өөрчлөлт, шинэчлэлтийн халуун цэг болж хувирсан юм (Ли Ман Ли, 2006, х.32-35). Түүнээс хойш ерөнхий эрдмийн боловсролын судалгааны хүрээнд үнэ цэн, үзэл баримтлал,

хичээл сургалтын тогтолцоо, гадаад дотоод харьцуулалт зэрэг сэдвээр макро болон микро түвшний цогц судалгааг эхлүүлсэн билээ. Арав гаруй жилийн онолын судалгаа болон практик туршилтаар суурь онолын талаар эдгээр чухал асуудлыг шинээр харж ойлгох болсон ба хамгийн бага нэгжээс хамгийн өргөн цар хүрээнд хүртэл ерөнхий загвар зураглалыг бий болгож чадсан ч хөрсөнд төдий л амжилттай бууж чадахгүй хэвээр байна.

Биеэ даасан ерөнхий эрдмийн сургалтын загвар хэлбэрээс тодорхой зорилго, агуулга, зохион байгуулалтын загвар, үнэлгээний тогтолцоо бүхий болтлоон хөгжсөн боловч эдгээр дөрвөн хүчин зүйл тус бүрийн ахиц дэвшлийг дэмжих болон хоорондын харилцаа хамаарлыг нягтаршуулах уялдан зохицсон хөгжлийг хангахад бас ч хол байсаар. Тиймээс соёлын боловсролын цогц хөгжлийг дэмжих (1998 оноос эхэлсэн) 20 жилийн туршилтын үр дүнг эргэн харж, хөгжлийн үйл явцад оршиж буй асуудал бэрхшээлийг задлан шинжлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Нэг. Хичээлийн зорилгыг тодорхойлох

1. Ерөнхий эрдмийн хичээлийн үнэ цэн, хандлага

Ерөнхий эрдмийн боловсрол нь анхандаа

хүмүүнлэгийн мэдлэг боловсрол, үнэ цэнийг практик ач холбогдлыг өсгөхөд чиглэгдэж байв. АНУ, Япон зэрэг хөгжилтэй улс орнуудын дээд боловсролын суурь ерөнхий эрдмийн сургалттай адилаар Хятадад ч мөн суурь мэдлэгийн ач холбогдлыг чухалчилж, хувь хүний төлөвшил хөгжлийг анхаарах болсон ч нийгмийн орчин, боловсролын философи уламжлал, онолын үндэслэлийн харилцан адилгүй байдлаас ямагт өөр өөр байр суурь, үзэл баримтлалыг баримталсаар иржээ.

Барууны орнуудын ерөнхий эрдмийн боловсролын суурь үзэл баримтлал голлон идеализм, этернализм, прогрессивизм, элементизм гэсэн дөрвөн урсгалд хамаардаг. Тэдний зарим нь хувь хүний чадавхийг төгөлдөржүүлэхийг (Нао Qin Si), зарим нь боловсролын нийгэмч ардчилсан чанарыг (Dewey), зарим нь чөлөөт хувь хүнийг хөгжүүлэхийг (Конан) чухалчилдаг ч дээд боловсролын мэргэжлийн ахиц хөгжилд тулгарч буй төрөл бүрийн асуудал бэрхшээлийг шийдвэрлэх ерөнхий зорилгод нэгддэг юм. Тэд “ерөнхий эрдмийн хичээл сургалтын зорилго нь оюутан ирээдүйд энэхүү мэдлэг чадвартаа түшиглэн нийгэмд хөл алдахгүй амьдрах, мэргэжлийн онцлогоос үүдэн бий болох хязгаарлагдмал хүрээний бэрхшээлийг аль болох даван туулахад нь туслах мэдлэг чадварын цогцыг эзэмшүүлэх, оюутныг бүхий л талаар хөгжүүлж, эцсийн дүнд биеэ даасан хувь хүн, чадварлаг иргэнийг бэлтгэхэд чиглэгдэх ёстой” (Ли Ман Ли, 1999, х.69-71) гэдэгт санал нэгддэг юм.

Үүнээс ялгаатай нь БНХАУ-ын дээд боловсролын ерөнхий эрдмийн боловсролын үзэл баримтлал хараахан салбарлаж ангиглагдаагүй бөгөөд үндсэндээ ерөнхий цогцоор нь эсвэл уламжлалт соёлын өнцгөөс харж, түүний цар хүрээ, уялдаа холбоог хүний амьдралын үнэт зүйлсийн талбарт тавьж, түүний зорилгыг соёлын илүү өргөн цар хүрээ, илүү гүн агуулгатай болгож, ертөнцийг үзэх үзэл, амьдралыг үзэх үзэл, мэдлэгийг үзэх үзлийг үнэт зүйлсийн ойлголттой нэгтгэн үзэж буй юм. Хятад хэлэнд “Соёлын боловсрол” хэмээх үг нь чухам энэ хандлагыг илтгэж байна. Судлаач Лю Ши Мин ерөнхий эрдмийн боловсрол бол “мэдлэгийн чухалчилж, чадварыг хөгжүүлэх явдал” (Лю Ши Мин, 2002, х.19-21) гэж үзсэн байдаг. Ли Ман Ли Хятадын дээд боловсролын ерөнхий эрдмийн сургалтын зорилгын онцлогийг “Анхаарах гурван зүйл” (соёлын ерөнхий боловсрол, инновацийг ашиглах чадвар, хувь хүний хөгжлийг тус бүр харгалзан анхаарах), “Хөгжүүлэх гурван зүйл” (оюутны соёлын боловсрол, соёлын тухайн багшийн

мэдлэг, их сургуулийн соёлын хэв маягийг хөгжүүлэх), “Уялдуулах гурван зүйл” (соёлын боловсрол ба соёлын тухай багшийн мэдлэг, соёлын боловсрол ба үзэл суртал, улс төрийн боловсрол, хүмүүнлэгийн боловсрол ба шинжлэх ухааны боловсролыг тус тус уялдуулах)-ээр багцлан үзсэн (Ли Ман Ли, 2006, х.32-33) байна.

Бээжин Их Сургуулийн ерөнхий эрдмийн сургалт нь “суурь мэдлэгийг бэхжүүлэх, нарийн мэргэшүүлэх, чадварт түшиглэн сургах, салбарлан хөгжүүлэх” гэсэн үндсэн зарчимд тулгуурладаг бол Цин Хуа Их Сургууль харин оюутны ёс суртахуун, оюун санаа, бие бялдрын хөгжлийг чухалчлахдаа сургалтын явцын бүхий л холбоост ёс суртахууны боловсролыг нэн тэргүүнд тавьдаг. Хятадын Ардын Их Сургууль бакалаврын түвшний сургалтад соёлын мөн чанарыг голлож, цогц чадварыг баримталж, улс төрийн зөв чиг хандлагыг ертөнцийг үзэх үзэл, үнэт зүйлстэй хамтад нь хөгжүүлэхийг нэн тэргүүнд тавьдаг. Бээжингийн Багшийн Их Сургууль харин соёлын боловсролд улс төрийн үзэл суртал, суурь мэргэжил, шинжлэх ухааны соёл, бие сэтгэлийн соёл боловсролыг багтаан үзэж, суурь мэдлэгээ бэхжүүлэх, мэргэжлээ дээшлүүлэх, чадвараа хөгжүүлэх, соёлтой байх шаардлагыг оюутнууддаа тавьдаг (Ли Ман Ли нар, 2001, х.28-29) байна.

2. Ерөнхий эрдмийн хичээлийн зорилго, агуулга

Хүн төрөлхтний өнөөгийн мэдлэгийг ерөнхийд нь нийгмийн ухааны, хүмүүнлэгийн ухааны, байгалийн ухааны гэж ангилж байгаа. Хятадын дээд боловсролын ерөнхий эрдмийн салбарын хамрах хүрээ өргөн бөгөөд улс төр, биеийн тамир, цэргийн явдал, тоо, байгаль шинжлэл, хүмүүнлэг, нийгэм судлал, компьютер, хэл шинжлэл, урлагийг багтаах ба заавал судлах хичээл, сонгон судлах хичээл, ур чадварын хичээлийн хэлбэрээр явагддаг.

Заавал үзэх хичээлд улс төрийн онол, гадаад хэл, компьютер, биеийн тамир, цэргийн явдал, зарим сургуульд мөн тооны ухаан, хууль зүйн хичээлүүд орно. Улс төрийн онолын хичээлийн гол зорилго нь оюутны улс төрийн үзэл баримтлалыг төлөвшүүлэх, улс төрийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, ёс суртахууны хүмүүжил олгох, зөв суртал хандлага төлөвшүүлэхэд чиглэдэг бол биеийн тамир, цэргийн явдлын хичээлийн зорилго нь оюутныг бялдаржуулах, бие бялдрын хүмүүжил олгоход чиглэдэг. Хэрэглээний ерөнхий суурь хичээлүүд нь голлон оюутны мэдлэг эзэмших чадварыг нэмэгдүүлж, чадвараа практикт хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Сургууль

бүрийн соёлын боловсролын хичээлийн агуулгын цар хүрээ өргөн бөгөөд оюутанд соёлын өргөн хүрээний мэдлэг боловсрол олгох зорилгын хүрээнд тооны ухаан, байгаль, хүмүүнлэг, нийгэм, улс төр, компьютер, хэл шинжлэл, урлаг, биеийн тамир хамгаалал, суурь ур чадвар зэрэг олон талын мэдлэг чадварыг багтаадаг юм.

Дээрхээс үзэхэд БНХАУ-ын их, дээд сургуулиудын ерөнхий эрдмийн сургалт нь өргөн цар хүрээ, бат бэх суурь мэдлэг, практик чадвар, соёлын ерөнхий боловсролыг дээшлүүлэн хөгжүүлэх нийтлэг зорилгыг биелүүлж байна.

3. Ерөнхий эрдмийн хичээлийн зорилго дахь гажуудал ба дутагдал

Нэн тэргүүнд БНХАУ ерөнхий эрдмийн хичээлийн сургалтыг хэрэгжүүлээд 20 гаруй жил болж байгаа бөгөөд үзэл онол, зорилго бүтцийн хувьд хараахан бүрэн системжиж төлөвшиж чадаагүй байгаа нь түүний зорилгыг бүдэгрүүлж, агуулга мөн чанарыг илтгэхэд бэрхшээл учруулж байна. Энэ нь улмаар их, дээд сургуулиудын мэргэжлийн боловсролын сургалтын чанарт сөрөг нөлөөг үзүүлж байгаа учир бид зайлшгүй өнгөрснөө эргэн харж, алдаа оноогоо дүгнэж, зарга хэмжээ авах шаардлагатай байна. Өнгөрсөн хугацаанд их, дээд сургуулиудын ерөнхий эрдмийн хичээлд ихэвчлэн суурь мэдлэгийн чанартай компьютер, гадаад хэл, хэл найруулга гэх мэт хичээлийг хамруулж байсан нь оюутны гадаад хэл, математикийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд үр нөлөөтэй байсан боловч мэргэжлийн мэдлэг, ур чадварын хөгжилд төдий л чухал ач холбогдлыг үзүүлсэнгүй.

Удаад нь, Хятадын боловсролын системд цогц сургалттай сургуулиас тусгай сургууль хүртэл янз бүрийн түвшний, төрөл бүрийн сургуулиуд боловсролын үйлчилгээ эрхэлж буй бөгөөд тухай бүрт ерөнхий эрдмийн хичээл харилцанадилгүй байх нь зүй. Гэвч өнөөгийн бодит байдалд цэргийн явдал, биеийн тамир, гадаад хэл, компьютер зэрэг заавал судлах хичээлүүдийг улсаас зориудаар тогтоож өгч байна. Улс төрийн мэдлэг боловсролыг гол болгосон цогц соёлын боловсрол, гадаад хэл, компьютерийн чадварыг дээшлүүлэх гэх мэт агуулгуудыг заавал судлах шаардлага тавигдаж, эсрэгээр нь суралцагчдын сонгон судлах боломж хумигдсан юм. Энэхүү нэгдсэн сургалтын зорилго нь нэгд төрөл бүрийн сургалттай, янз бүрийн түвшний сургуулиудын хувийн онцлогийг хангаж чадахгүй, хоёрт ерөнхий эрдмийн хичээлийн өөрийнх нь бие даасан онцлогт харшилж байна. Үүнээс гадна, сургуулиудын төрөл (цогц сургалттай сургууль, тусгай сургууль гэх мэт), шатлалын онцлог (мэргэжлийн сургалттай сургууль, судалгаа

голлосон сургууль гэх мэт), сургалтын зорилгын харилцан ялгаа, цар хүрээний онцлогуудыг бүдэгрүүлснээр ерөнхий эрдмийн хичээлийн хэрэгжилтэд хүндрэл учруулж буй талтай.

Эцэст нь, ерөнхий эрдмийн бүлгийн аль салбар хичээл ч гэсэн мэдлэг, чадвар, сэтгэлзүйн гэсэн гурван шатны зорилгыг биелүүлэх шаардлагатай. Мэдлэг ба чадварт суралцах нь урьдал үе шат, харин сэтгэлзүй, хандлагад суралцах нь ерөнхий эрдмийн боловсролын эцсийн зорилго юм. БНХАУ-ын их, дээд сургуулиудын ерөнхий эрдмийн боловсролын өнөөгийн байдал нь мэдлэг буюу агуулгыг эзэмших болон суурь ур чадварыг эзэмших шатанд гацчихаад, эцсийн зорилгоо бүрэн дүүрэн биелүүлж төдий л чадахгүй байгаад бидний бэрхшээл оршиж буй. Ихэнх хүмүүс ерөнхий эрдмийн хичээлүүдийг зөвхөн хичээл төдийд ойлгодог ч энэ нь чухамдаа нэг төрлийн хандлага, нэг төрлийн сурах арга барил, насан туршийн эрэл хайгуул юм.

Хоёр. Ерөнхий эрдмийн хичээлийн агуулгын сонголт

1. Ерөнхий эрдмийн хичээлийн агуулгыг сонгох үндэслэл

Хичээлийн зорилго болон агуулга нь харилцан нягт уялдаж байдаг. Ялангуяа хичээлийн агуулгыг тодорхойлоход зорилго тодорхой байх шаардлагатай ба суралцагчдад дэвшүүлэх агуулга нь ерөнхий эрдмийн сургалтын зорилго болон хичээлийн зорилгын шаардлагад нийцэж, тэдгээрийг амжилттай хэрэгжүүлэх баталгаа болох учиртай. Зохиогчид агуулгыг сонгохдоо оюутны бие бялдар, мэдлэг, сэтгэл оюун, үйл ажиллагаа гэх мэт бүхий л талыг жигд хөгжүүлэх цогц хөгжлийг зорилго болгодог ч, оюутны хувьд авч хэлбэл тэдгээрийн аль нэг тал нь давамгайлж, эсвэл орхигдож байдаг. Тухайлбал, судлаач Ван И Чю “Ерөнхий эрдмийн боловсрол эзэмшсэн хүн нь “Өөрийгөө хөгжүүлж чаддаг, авъяас чадвар, давуу талаараа нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж чадах, бүхий л талаар чөлөөтэй хөгжиж чаддаг байх ...” (Ван И Чю, 2006, х.66-67) гэж үзсэн бол Хуан Кун Жинь “Ерөнхий эрдмийн боловсрол бол бүхий л талын мэдлэгийг жигд эзэмшсэн хүнийг бэлтгэх сургалт мөн” (Хуан Кун Жинь, 2006, х.34-35) гэж үзсэн нь ерөнхий хөгжлийн ойлголт болно. Иймээс ерөнхий эрдмийн хичээлийн агуулгыг тодорхойлоход агуулгын гүнгийг бус, харин цар хүрээг чухалчилдаг нь хүн төрөлхтний мэдлэгийн цогцыг тусгаж, соёлын өвийг төлөөлөх суурь шинжлэх ухааны мэдлэгт сургаснаар суралцагчид тал бүрийн суурь чадвар эзэмшүүлэх болон

баялаг мэдлэгийн суурьтай болгохын тулд ажээ. Энэ зарчим, үзэл баримтлалыг ихэнх сургуулиуд ерөнхийд нь хүлээн зөвшөөрч, сургалтын хөтөлбөр төлөвлөгөөндөө нэгэнт хэрэгжүүлж эхлээд байгаа билээ.

Бидний оршин буй өнөөгийн нийгэм-цаг үе бол мэдээллийн эрин үе. Энэ нийгмийн хурдацтай хөгжил дэвшилд хөл нийлүүлэхийн тулд бидний хичээл сургалтын агуулга нь шинжлэх ухаан технологийн шинэ үр дүнг эрхбиш тусгах нь зүй бөгөөд энэ бол технологийн инновацийн нийгэмч үзэл хандлага болно. Үүнтэй адил шалтгаанаар глобалчлалыг дагалдаад тухайн үндэстний боловсролын өнгө төрхийг илтгэх олон талт соёлын хэв маяг нь өнөөгийн нийтлэг хандлага болоод байгаа. Иймээс ерөнхий эрдмийн сургалт, хичээлийн агуулгын сонголтод олон талт соёлын үзэл хандлагыг баримталж, соёл уламжлал, амьдралын хэв заншил, үнэт зүйлс зэрэг харьцангуй даяарчлалын шинжтэй агуулгуудыг сонгох болжээ.

2. Ерөнхий эрдмийн хичээлийн талбар

БНХАУ-ын дээд боловсролын ерөнхий эрдмийн хичээл нийт хичээлийн гуравны нэг хувийг эзэлж байгаа нь харьцангуй тохиромжтой харьцаа гэж үзэж буй (Ли Ман Ли нар, 2001, х.28-29). АНУ-тай харьцуулбал, ерөнхий эрдмийн хичээлийн эзлэх хувь үндсэндээ ижил байна (АНУ 40-50%, БНХАУ 30-49%) (Лю Тую нар, 2004, х.19-20). Хичээлийн дотоод зохион байгуулалтаас харвал, Хятадад улс төрийн онол, цэргийн явдал, биеийн тамир, гадаад хэл, компьютер зэрэг улсаас тогтоосон заавал судлах хичээлүүд нийт хичээлийн ихэнх хувийг эзэлж, бүтцийн хувьд заавал судлах хичээл голлож, сонгон судлах хичээлүүд дагалдах үүрэгтэй оролцож байна (Ли Ман Ли нар, 2001, х.28-29). Бээжингийн Их Сургуулиар жишээлбэл, бакалаврын түвшний сургалтын нийт хичээлд ерөнхий эрдмийн хичээл 11, түүнд улс төрийн онол, гадаад хэл, компьютер, тоо, биеийн тамир, цэргийн явдлын онол зэрэг заавал судлах хичээлүүдийг нийт 40 кредит цагаар судалж байна. Харин соёлын боловсролын хичээлд тоо ба байгалийн ухаан, нийгмийн ухаан, философи ба ёс зүй, түүх ба соёл, хэл утга зохиол ба урлаг гэсэн бүлэг судлагдахуунуудыг багтааж, бүлэг тус бүрээс хамгийн багадаа хоёр кредит цагийг сонгон, нийт 16 кредитийг заавал судална. Хэл утга зохиол ба урлагийн бүлэгт хүмүүнлэгийн 1, урлагийн 1 хичээлийг заавал багтаах ба соёл урлагийн мэргэжлээр суралцагч бол тоо ба байгалийн ухааны бүлгээс хамгийн багадаа 2 хичээл сонгон судалж байна.

Сургуулийн статус харилцан адилгүйгээс

хамааран сургуулиуд улсаас тогтоосон нийтлэг хичээл тохируулгын хүрээнд өөрсдийн агуулгын онцлогийг суулгаж хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж байна. Тухайлбал, Бээжингийн Багшийн Их Сургуулийн жишээн дээр авч үзэхэд боловсролын үнэлгээ, гэрийн боловсрол, тусгай бүлгийн хүүхдийн боловсрол, сургуулийн удирдамж зөвлөгөө, ангийн ажил ба бүлэг судлал, гадаадын боловсролын шинэчлэлийн үйл явцын судалгаа, багшийн харьцуулсан боловсрол, багшийн ярих урлаг зэрэг (Ли Ман Ли нар, 2001, х.28-29). боловсролын суурь хичээлүүдийг бүх оюутанд тохируулсан бол харин Юнь Наний Үндэстний Их Сургууль “Үндэстний соёл” (Фэнь Иян Кун, 2007, х.30-31) хичээлийг бүх оюутандаа тохируулсан байх жишээтэй. Сонгон судлах хичээл ч мөн сургууль бүрт харилцан адилгүй. Жишээлбэл, Бээжингийн Их Сургууль хүмүүнлэгийн ухаан, Цин Хуа Их Сургууль номын сангийн цуврал лекцийг сонгохыг оюутнууддаа санал болгодог.

3. Хичээлийн агуулгын сонголтод оршиж буй асуудал бэрхшээл

Нэгд, ихэнх сургуулийн хичээлийн агуулга АНУ-ын загварыг шууд авч ашигласан. АНУ-ын дээд боловсролын ерөнхий эрдмийн хичээл нь хүмүүнлэг, нийгмийн ухаанаар голлодог. Цэвэр технологийн сургалттай сургуулийн ерөнхий эрдмийн хичээл ч мөн хүмүүнлэг, нийгмийн ухааны хичээлүүдийг харьцангуй өндөр хувьтай тусгадаг. Хятад ч мөн адил. Маш олон сургууль Харвардын цөм сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх оролдлогыг хийсэн. Тухайлбал, Бээжингийн Их Сургуулийн нийтээр сонгон судлах хичээлийн загвар нь Харвардын 1978 онд хэрэгжүүлсэн таван төрөл хуваах загварыг хуулбарласан (Ган Ян, 2006, х.19-21) ч бодит байдал дээр Принстон тэргүүтэй соёл хүмүүнлэгийн болон шинжлэх ухаан технологийн салбарын оюутнуудад ялгаатай шаардлага тавьдаг их сургуулиуд, мөн Массачусетс зэрэг шинжлэх ухаан, технологийн салбарын их сургуулиудын загвараас мөн тусгасан байдаг. Харамсалтай нь дотоодод энэ талын судалгаа бага хийгдсэний учир зарим судлаачид Хятад улс ялангуяа технологийн салбарын сургуулиудад сүүлийн хоёр загварыг авч хэрэглэх нь тохиромжтой гэсэн саналыг дэвшүүлээд байна (Ган Ян, 2006, х.19-20).

Хоёрт, мэдлэг эзэмшүүлэх чиглэл тодорхой байх шаардлагатай буюу хичээлийн бүтэц тохирохгүй байх: Мэдлэгийн сонголтоор хичээлийн бүтэц дизайныг төлөөлүүлснээр оюутанд насан туршийн, өргөн цар хүрээтэй мэдлэгийн системийг бий болгох боломжгүй

юм. Хичээлийн агуулгад салбар хоорондын харилцан хамаарал, уялдаа алдагдах нь цаашлаад шинжлэх ухаан хоорондын, соёл хоорондын уялдаа хамаарал алдагдахад хүргэж, улсаас бодлогоор дэмждэг чухал салбаруудад нөлөөлөх боломжтой. Өнөөгийн БНХАУ-ын их, дээд сургуулиудын соёл боловсны төрлийн хичээлийн агуулга мэргэжлийн болон хэрэглээний чанарт чиглэж байгаа бөгөөд зарим сургуулиудад мэргэжлийн зарим хичээлд тавих шаардлага, ач холбогдлыг бууруулж, соёл боловсны сонгон судлах хичээл болгон хөтөлбөр төлөвлөгөөндөө шингээх үзэгдэл гарч байна.

Гуравт, оюутны чөлөөт сонголтын боломж бага. Хэдийгээр бүхий л сургуулийн соёл боловсролын хичээл нь нэг төрлийн нийтлэг үндсэн хичээл гэж үздэг ч, заавал судлах хичээл олон, оюутанд сонголт хийх боломж бага, оюутны суралцах хүсэл сонирхлыг хөдөлгөх боломжгүй, үр дүн хангалттай бус, ерөнхийдөө сургалтын зорилго, агуулгыг бүрэн дүүрэн хангахгүй, ерөнхий эрдмийн боловсролын үндсэн үзэл баримтлалыг зүй зохистой хэрэгжүүлж чадахгүй байна.

Гурав. Ерөнхий эрдмийн хичээлийн хэрэгжилт

1. Хичээлийн хэрэгжилтийн үндсэн арга зам

БНХАУ-ын их, дээд сургуулиудад ерөнхий эрдмийн хичээлийн 80-аас дээш хувийг заавал судлах хичээл эзэлж, бүгдийг нь нэг, хоёрдугаарт курсэд судлахаар төлөвлөсөн байдаг тул ихэнх нь поток лекцийн хэлбэрээр (Жан Шоу Сун, 2003, х.44-45), маш бага хувь нь семинар, танхимын ярилцлагын хэлбэрээр ордог (Бээжингийн Их Сургуулийн хүмүүнлэгийн ухааны хичээл, Цин Хуа Их Сургуулийн номын сангийн цуврал лекц). Мэдээжийн хэрэг өнөөгийн практикаас харахад, ахлах курсуудад дан бүтцэт хичээлийн загвар (цөөн оюутанд нарийвчилсан сэдвээр хичээллэх) илүү тохиромжтой мэт харагдаж байгаа ч энэ бол боломжит нэг л арга зам юм. Хэрэв манай бүх их сургуулиуд энэ арга замыг хэрэгжүүлээд эхэлвэл, бидний төсөөлсөн зорилгод хүрч чадахгүйн дээр ерөнхий эрдмийн боловсролын үндсэн зорилгоос хазайхад хүрнэ. Гадны орнуудын туршлагаас харахад, ерөнхий эрдмийн боловсролын сургалт хичээлийг төлөвлөн явуулахдаа тухайн сургуулийн онцлог, давуу тал, нөөц бололцоо, ирээдүйн хөгжлийн чиг хандалагад үндэслэн олон төрлийн арга замыг хэрэгжүүлсэн байдаг.

2. Хичээлийн хэрэгжилтийн бүтэц

Өнөөгийн байдлаар БНХАУ-ын ихэнх их, дээд сургуулиуд тусгайлан ерөнхий эрдмийн хичээлийг хэрэгжүүлэх зохион байгуулалтыг бүрдүүлж чадаагүй байна. Ерөнхий эрдмийн хичээлийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй

байгаагийн учир шалтгааныг олон судлаачид бие даасан, тусгай зохион байгуулалт-удирдлагын бүтцийг тохируулж чадаагүйтэй холбон тайлбарлаж байна (Лө И, 2007, х.46-47). Ли Ман Ли ерөнхий эрдмийн боловсролын сургалтыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд бид нэн тэргүүнд бүтцийн хувьд түүний статусыг баталгаажуулж, зохион байгуулалтын хувьд шинэчлэлийг баримтлах хэрэгтэй гэж үзсэн буй. Тухайлбал, ойрын үед Фудан Их Сургууль зэрэг зарим сургуулиуд ерөнхий эрдмийн сургалт хариуцсан тусгай хэлтэс байгуулсан нь дээрх саналыг дэмжсэн явдал юм.

3. Хичээлийн хэрэгжилт дэхь багшийн нөхцөл боломж

Ерөнхий эрдмийн хичээлийн зорилгыг бүрэн дүүрэн биелүүлэхэд шаардагдах нөхцөл боломжийг анхааран судлах шаардлагатай. Үүнд, Сургалтын орчны нөхцөл (материаллаг, оюуны болон сэтгэлзүйн орчин), сургуулийн удирдлагын болон багшийн нөхцөл боломж, түүн дунд багш хичээлийг удирдан явуулахад тулгарах, шийдвэрлэх болон олон талын дагалдах хүчин зүйлсийг багтаан үзнэ. Сургалтыг явуулахад мэргэжлийн өндөр ур чадвартай багшлах боловсон хүчин нэн чухал боловч, өнөөгийн бодит нөхцлөөс харахад манай их, дээд сургуулиудад бидний шаардлагыг бүрэн хангах багшлах хүчин тийм ч хангалттай бус байна. Нэгд, зарим багш нар хэдийгээр өөрийн мэргэжлийн салбарын мэдлэг чадварыг өндөр түвшинд эзэмшсэн ч, түүнийгээ ерөнхий эрдмийн хичээлд нэвтрүүлэн ашиглах чадвар туршлага дутмаг. Хоёрт, багш ерөнхий эрдмийн боловсролын талаарх мэдлэг ойлголт хангалтгүйн улмаас түүнийг ердийн мэдлэг төдийд үнэлж ойлгон, үл чухалчлах, идэвхи чармайлт гаргахгүй байх. Гуравт, зарим багш нарын ажил хэрэгч чанар, зан суртахууны төлөвшилийг хөгжүүлэх шаардлагатай (Жу Ян Фэй нар, 2005, х.73-74) болно.

Дээрхээс дүгнэвэл, БНХАУ-ын дээд боловсрол дахь ерөнхий эрдмийн сургалтын хэрэгжилтэд хичээл сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга замын олон талт хэв загвар, тусгай хичээлийн хэрэгжилтийн зохион байгуулалт, эсвэл хичээлийн сургалтын орчин дахь багшийн нөхцөл боломж зэрэг олон талын хүндрэл бэрхшээлүүдийг шийдвэрлэх, даван туулахын тулд бид чамгүй урт замыг туулах шаардлагатай байна.

4. Ерөнхий эрдмийн хичээлийн үнэлгээ

Ерөнхийд нь харахад, БНХАУ-ын их, дээд сургуулиудын ерөнхий эрдмийн хичээлийн заавал судлах хичээлээр оюутанд эзэмшүүлсэн мэдлэг, чадварыг сургуулийн хэмжээний нэгдсэн

шалгалтаар, харин соёл боловсролын төрлийн сонгон судлах хичээлийг харьцангуй уян хатан арга замаар үнэлдэг. Нэгд, Ерөнхий эрдмийн хичээлийн олонхыг улсаас тогтоосон заавал судлах хичээл эзэлдэг бол соёл боловсролын талын хичээлийн олонхыг сургуулиас тогтоож, оюутан суралцагчдын бодит хүсэл сонирхлыг маш бага анхаардаг нь тэдний зүгээс сурах сонирхол буурах хандлагаас зайлсхийж чадахгүй. Нөгөө талаар, хичээл сонгогчийн тоо болон шалгалтын дүнгээс харахад хичээлийн үр дүнгийн сайн муу нь бүхий л үнэлгээний түвшинг доош татаж байна. Хоёрт, их, дээд сургуулийн тогтолцоонд соёлын боловсролын хичээл (нийтээр сонгох хичээл) нь бакалаврын түвшний сургалтын үндсэн болон нэмэлт хичээлүүд болдог (Ган Ян, 2006, х.19-20). Иймээс сургалтын системд эдгээр хичээл нь чухамдаа нэмэлт, хоёрдогч ач холбогдолтой байдаг. Ингэснээр нийтээр сонгох хичээлд хатуу шаардлага, дасгал сургуулилт шаарддаггүй, хэд хэдэн анги бүлгийг хамтатган хичээллэдэг, эсвэл хамгийн ихдээ хичээлээс гадуурх сонирхлыг дэмждэг. Гуравт, хичээлийн үнэлгээ нь эрхбиш шинжлэх ухааны бодит үнэлгээний шалгуурыг хангасан байх нь зүйтэй. Өнөөгийн ерөнхий эрдмийн хичээлийн хувьд авч үзвэл, сургуулийн түвшинд удирдан чиглүүлэх чиг үүрэг бүхий үнэлгээний тогтолцоо, хичээл сургалтын түвшинд бодит бөгөөд хатуу чанга үнэлгээний удирдамж болон тохиромжтой арга хэлбэр үгүйлэгдэж, харин багшийн түвшинд тодорхой хэв загвар үгүй байна. Иймээс зарим судлаачид тогтмол хугацаан дахь сургалтын үйл ажиллагааны явц, хэрэгжилтэд үүссэн асуудлыг үнэлж дүгнэн, багш, оюутны бүхий л талын цогц хөгжлийг дэмжих ач холбогдол бүхий, хичээлийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлж (Лө И, 2007, х.46-47), сургалтын хөтөлбөр, сургалтын менежментийг сайжруулж, сургалтын үнэлгээний цогц механизмыг бүрдүүлэхийг санал болгодог билээ.

Дүгнэлт

Их, дээд сургуулиудад соёлын боловсрол олгож эхэлснээс хойш харьцангуйгаар хөгжсөн боловч, ерөнхий эрдмийн хичээлийн өөрийнх мөн чанар, агуулгын дуталтай байдлаас хамааран түүнийг гүнзгий ойлгож мэдэхэд олон асуудал бэрхшээл тулгардаг. Иймээс тэдгээр асуудал бэрхшээлийн учир шалтгааныг тодорхойлсны үндсэн дээр түүний гол чиг үүргийг нь баталгаажуулах шаардлага бидний өмнө зүй ёсоор тавигдаж байна.

- Агуулгыг тасралтгүй гүнзгийрүүлэх.

Хичээлийн хөтөлбөрийн агуулга нь ерөнхий суурь үзэл баримтлалыг тусгасан байх. Өнөөгийн байдлаар ерөнхий эрдмийн хичээлийн хөтөлбөрийн агуулга нь хуучин мэргэжлийн хэв загварт түшиглэсэн хэвээр байгаа. Энэ төрлийн хичээлийн агуулгад мэргэжлийн чанар өндөр бөгөөд оюутны мэргэжлээс гадуурх сэтгэлгээ, чадварыг хөгжүүлэхэд төдий л ач холбогдолтой бус. Ерөнхий эрдмийн хичээлийн хөтөлбөр бол суурь, нийтлэг, уялдсан агуулгыг шаарддаг бөгөөд мэдлэг, хандлага, сэтгэлгээний хэлбэр зэрэг олон талаар оюутныг хөгжүүлж, оюутны нийгэмд дасан зохицох чадварыг дээшлүүлдэг. Ерөнхий эрдмийн хичээлийг тохируулахдаа практик асуудлыг судлах, шийдвэрлэх агуулгыг гол шугам болгох саналыг дэвшүүлэе.

- Үнэлгээний механизмыг сайжруулах. Үнэлгээ нь хичээл сургалт дахь төрөл бүрийн хүчин зүйлсийн хэрэгжилтэд үүсэх асуудал бэрхшээлийг илрүүлж, хичээлийн хөтөлбөрийн загвар бүтцэд харьцуулалт хийх, хичээл сургалтын зорилгын биелэлтийг үнэлэх, хөгжлийн арга замын үндэслэлийг тодруулах зэрэг гол чухал менежментийн чиг үүрэгтэй. Тиймээс ерөнхий эрдмийн хичээл сургалтыг амжилттай явуулахын тулд үнэлгээний механизмыг шинэчлэх зайлшгүй шаардлагатай. Зөвхөн хичээлийн зорилго, агуулга, хэрэгжилтийг шинэчлэхийг анхаараад, үнэлгээний механизмыг сайжруулахыг орхигдуулах нь ерөнхий эрдмийн хичээлийг бүхий л талаар хөгжүүлэх ажлыг бүтэлгүйтэхэд хүргэнэ.
- Ерөнхий эрдмийн боловсролын үр дүнд дээр өгүүлсэн дотоод хүчин зүйлсээс гадна, мөн сургуулийн удирдлагын сургалтын үйл ажиллагааг удирдан явуулах зарчим үндэслэл, багшийн соёл, сургалтын тогтолцоо зэрэг зарим чухал гадаад хүчин зүйлс нөлөөлдөг бөгөөд цаашид эдгээр судлагдахууныг ч мөн анхааран үзвэл зохилтой гэж үзэж байна.

Ном зүй

- Ван И Чю. (2006). Их, дээд сургуулийн ерөнхий эрдмийн болон соёлын боловсролын сургалт. –Бээжин: Бээжингийн Их Сургуулийн сургалтын үнэлгээ. Дугаар 7.
- Ган Ян. (2006). Их Сургуулийн ерөнхий эрдмийн хичээлийн хоёр төвт холбоос. Сургалтын унших материал. Дугаар 4.
- Жан Шоу Сун. (2003). БНХАУ-ын дээд боловсролын ерөнхий эрдмийн

- боловсролын ойрын арван жилийн судалгааны дүн мэдээ. Боловсролын онол, практик. Дугаар 10.
- Жу Ян Фэй, Ши Юн Ли, Чөн Жан Рун. (2005). *MIT-ээр БНХАУ-ын их, дээд сургуулиудын ерөнхий эрдмийн хичээлийн хөгжлийн стратеги*. Цин Хуа Их Сургуулийн боловсролын судалгаа. Дугаар 4.
- Ли Ман Ли. (2006). БНХАУ-ын их, дээд сургуулиудын ерөнхий эрдмийн боловсролын зарчим, бүтцийн асуудалд. –Бээжин Их Сургуулийн сургалтын үнэлгээний тойм. Дугаар 7.
- Ли Ман Ли. (1999). Ерөнхий эрдмийн боловсрол: Нэгэн зүйлийн үзэл баримтлал. –Бээжин: Цин Хуа Их Сургуулийн хэвлэлийн хороо.
- Ли Ман Ли., Ян Ли, Сүн Хай Тао. (2001). Манай улсын их, дээд сургуулиудын ерөнхий эрдмийн сургалтад анализ хийсэн нь. (Бээжин Их Сургууль, Цин Хуа Их Сургууль, Ардын Их Сургууль, Бээжингийн Багшийн Их Сургуулийн жишээн дээр). Цин Хуа Их Сургуулийн боловсролын судалгаа. Дугаар 2.
- Лө И. (2007). *1990-ээд оноос хойших манай улсын дээд боловсролын ерөнхий эрдмийн сургалтын судалгааны асуудал, бэрхшээлүүд*. Орчин үеийн дээд боловсрол. Дугаар 3.
- Лю Ши Мин. (2002). Дээд боловсролын сургалтын тогтсон хэв шинж ба оюутны хөгжлийн үнэ цэн, хандлага. БНХАУ-ын дээд боловсролын судалгаа. Дугаар 10.
- Лю Тую нар. (2004). БНХАУ, АНУ-ын зарим их сургуулийн ерөнхий эрдмийн хичээлийн практикт харьцуулсан судалгаа. –Ляо Нин: Хар Мөрөн мужийн дээд боловсролын судалгаа. Дугаар 3
- Хуан Кун Жинь. (2006). Их, Дээд сургуулийн ерөнхий эрдмийн хичээлийн суурь үзэл баримтлал, хөтөлбөр төлөвлөгөө. –Бээжин: Бээжингийн Их Сургуулийн сургалтын үнэлгээ. Дугаар 7.
- Фэнь Жиян Кун, Жу Суэ Вэнь. (2007). Их сургуулийн бакалаврын сургалт дахь ерөнхий эрдмийн хичээлийн бүтэц, зохион байгуулалт (Юань Наний Үндэстний Их Сургуулийн жишээн дээр). Дээд боловсролын судалгаа. Дугаар 3.
- Лө И. (2007). *1990-ээд оноос хойших манай*

Difficulties and progresses of university general academic subjects in china

Zhao Na Si Tu,
Inner Mongolia Normal University

Abstract

As a result of conducting a pilot study for improving all aspects of educational quality of Chinese universities, which has been studied around for over a decade, pursuant to the purpose, content, implementation, and evaluation, the common problem of the general academic subjects' training

has been defined. The main function of general academic subject training is to emphasize on deepening the content and improving the evaluation system. The compulsory study occupied more than 80% of the general academic subjects in China and it is planned to be studied all in freshman and sophomore courses, most of them are in the form of lecture but seminars and classroom interviews are very less. Therefore, the question what positive and negative impacts have the planning for general academic subject course on learning?

Also, we have studied the issues how in foreign countries the subjects have been studied. There are a number of ways in which different types of approaches have been implemented based on the specific features, advantages, resources, and future development trends.

Keywords

General education, goals, content, implementation and evaluation,